

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:Тус Тамгын газарт 5 дугаар сард 25 албан бичиг ирснийг удирдлагад танилцуулж, цохолт хийлгэн бүртгэлээр холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

Тамгын газраас 5 дугаар сард 117 албан бичиг явсан. Явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан.

5 дугаар сард хариутай 13 албан бичиг ирсэн. Үүнээс-8 албан бичиг хугацаандаа явсан, хугацаа болоогүй-5 байна. Хариутай бичгийн бүртгэлийг хөтөлж, хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сарын байдлаар сумын Засаг даргын “А”захирамж-29, “Б” захирамж-3 Тамгын газрын даргын “А” тушаал-6, “Б” тушаал-9 тус тус гарсан байна.

Архивын программд цаг тухай бүр ирсэн явсан албан бичгийг бүртгэн шивж байна.

Байгууллагын архиваас нийт 59 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн байна.

2004-2008 оны байнгын баримтыг скайнердан цахим хэлбэрт оруулсан. 2005-2020 оны архивын баримт бичгийн цэгцлэх ажил үргэлжлэн явагдаж байна.

Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай багийн Засаг даргын 177 ш тодорхойлолт гаргаж үйлчилсэн. Мөн багийн ажлын алба 85 өрхөөр орж ажилласан.

Төрийн үйлчилгээний оператораас 5-н төрлийн 10 үйлчилгээ лавлагааг гаргаж иргэдэд түргэн шуурхай үйлчилсэн байна. Үүнийг ангиллавал:

- Гэрлэсний бүртгэлийн лавлагаа-1
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-2
- Шүүхийн шийдвэрийн өр төлбөргүй эсэх лавлагаа-5
- Иргэний үнэмлэхний лавлагаа-1
 - Оршин суугаа хаягын лавлагаа-1

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:2021 оны хаврын тариалалт эхлээд байгаа бөгөөд 0,1 га талбайд 5 нэр төрлийн хүнсний ногоог 6 иргэн тариалсан.

Сумын хэмжээнд 15 аж ахуй нэгж, 51 иргэн төмс 20.2 га, бусад хүнсний ногоог 15.1 га-д тариалаад байна.

Тамхины болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн 13 аж ахуй нэгжид зөвшөөрөл олгосон.

Аймгийн Засаг даргын А/263 тоот захирамж болон МХЕГазрын даргын 01/05 тоот удирдамжийн хүрээнд Баруун-Урт суманд худалдаа, үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 93 аж ахуй нэгж, иргэн хамруулан УОК-ын даргын түр журмын хэрэгжилтэд ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 08-20-ны өдрүүдэд хяналт хийж ажиллалаа.

Тухайн худалдаа үйлчилгээний газруудад УОК-ын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 41 тоот тушаалаар баталсан түр журмын танилцуулж, баталгаажуулан, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулж, амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй байх, үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжин бүртгэл хөтлөх, хүн хоорондын зайг бариулах, тэмдэг тэмдэглэгээг сэргээн ажиллах талаар зөвлөгөө, зөвлөмж өгч улсын байцаагчийн шалгалтын тэмдэглэлээр үүрэгжүүлэн, мөн Гамшгаас хамгаалах хяналтын улсын хяналтын улсын байцаагч томоохон худалдааны төвүүдэд мэдэгдэл хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

НОГООН БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЭЦ, ХОГ ХАЯГДЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шаргын модод ХХК нь ОНХС-н хөрөнгөөр 12.5 сая төгрөгийн өртөгөөр Боловсрол хороололд 400м, Нарлаг хороололд 300 м газарт нийт 2100 ш модыг шинээр тарьсан.

“Ойжуулалт хайлааст” ХХК – нь 7.2 сая төгрөгийн өртөгтэй 1400 ш мод, 40 кг зүлэгний үр нийлүүлэх ажлыг 100% гүйцэтгэсэн.

“Ойжуулалт хайлааст” ХХК – нь 9.9 сая төгрөгийн өртөгтэй 1937 м 2 зүлэгжүүлэх ажлыг 3 хэсэг газарт 4-н замын урд хэсэгт 700м², 36а баруун тал, 500м 2, Одконы баруун тал 600м 2 талбайг тэгшилж бор шороог дэвсэж бэлтгэл бэлэн байдлыг хангаж байна.

Боловсролын байгууллагын 100-н жилийн ойг угтаж 4 ЕБС, 11 СӨБ нийт 2000 ш модыг Боловсрол төгөлд тарьж ургуулсан.

Нийтийн эзэмшлийн зам дагуу 4 хэсэг газарт 1200 ш модыг шинээр тарьсан.

2021 оны хаврын тарилтын мэдээгээр 11501 модыг шинээр тарьж 99,0 сая.төгрөгийн зардал гаргасан байна.

5-р тойргийн модыг хамгаалах зурвас байгуулах ажилд Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 50,0 сая.төгрөг, сумын ОНХС-н хөрөнгөөр 10.0 сая.төгрөгийг шийдвэрлүүлж 5.8 км хамгаалах материалыг худалдан авсан.

Японы засгийн газрын Ядуурлыг бууруулах сангаас хэрэгжүүлж буй “хатуу хог хаягдлын цэгийг янзлах, дахивар хог авах” төслийн баг 05-р сарын 25-28-ны өдрүүдэд ажиллаж төслийн бэлтгэл ажил хийгдэж байна.

Сумын шуурхай штаб 24 цагийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж ажилгүй 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан.

Нохой устгалын ажлыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-аар гүйцэтгэж байна. Энэ сард нийт 30 нохой устгасан байна.

Шарилжгүй Баруун-Урт аяны хүрээнд ОНХС-н хөрөнгөөр 15.0 сая.төгрөгийг тусган Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр захирамж гаргаж, гэрээ байгуулаад байна.

Нүхэн жорлонгын ариутгалын ажлын бэлтгэл тооцоо судалгаа хийгдэж байна. Аймгийн БОАЖГ-аас эко бохирын цооног 10 ш хийх, 300 бохирын цооног ариутгах ажлыг төсөв тооцоо хийгдсэн байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн 2021 оны 05-р сарын 12-ны өдрийн 17-04-319/01 албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.

Элс хайргыг зөвшөөрөлгүй авах талаар экологийн цагдаагийн албатай хамтран хяналт тавьж 2 зөрчлийг харъяалалын дагуу шилжүүлсэн.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаа”-наас ус бохирдуулагч 46 ААНБ-н хаягдал усны дүгнэлтийг гаргаж ирүүлсэн.

5,7-р багийн үерийн далангийн хамгаалалтын засварын ажлыг хийж байна.

27 б,в, 36,38-н айлын дээвэр засварын тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулж тендер зарлах ажил бэлэн болсон.

7-р багийн орц засварын ажлын хөрөнгө 15.0 сая.төгрөг Уртын гэгээ ОНӨААТҮГ-т шилжүүлсэн. .

Гудамж талбайн нэрэмжит хаягжуулалтын ажлыг Сумын ИТХТ-н хуралдаанаар хэлэлцэж 1-р багийн нутаг дэвсгэр Мандал хорооллын хойд их буутай хөшөөг “Соёмбот цэцэрлэгт хүрээлэн” болгосон.

Баруун-Уртын голын 4 замын уулзвараас ҮТП-н баруун хойд тал хүртэлх

Хууль эрх зүйн чиглэлээр:Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2021 оны төлөвлөгөөний дагуу дараах чиглэлээр хяналт хийж, зөвлөмж өгч, зөрчлийг арилгаж ажилласан. Үүнд:

- Албан хаагчдын баримт бичгийн боловсруулалт.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан эсэх, гүйцэтгэл үр дүнд хяналт тавьж, биелэлтийг тооцож буй эсэх.
- Баруун-Урт сумын 2021 оны хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг хяналтад авч, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нэмэлтээр тусгасан эсэх.
- Хариутай бичгийн барагдуулалт.
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэж архивт тушаасан байдал.
- Өөрийн хариуцсан салбар, эрхэлсэн ажлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хяналтад авсан эсэх.
- Өргөдөл, гомдлын барагдуулалт, эргэх холбоотой ажилласан эсэх.

“Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан.Үүнд:

- 2 постор бэлтгэн хүргэсэн.
- АА нийгэмлэгтэй хамтран архины хэрэглээг, хэрхэн хорт зуршлаасаа салах тухай подкастыг бэлтгэн хүргэсэн.
- АА-ийн цуглаан хийх зориулалтай 27 б байрны 1 дүгээр орцны подвалийг засах, засвар хийх ажил эхлээд байна.
- Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулан, хариу мэдээлж ажилласан. Өргөдөл, гомдлын барагдуулалт 100% байна.
- Сумын Засаг даргын захирамжийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавин хяналтын дагалдах хуудас хөтлөн ажиллаж байна.
- Сумын харьяаны 15 төсөвт байгууллагын 2021 оны хагас жилийн ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийж байна.

ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Баруун-Уртаас Улаанбаатар чиглэлийн хөдөлгөөнд хяналт тавих, постын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажиллаж байна.

Үүнд:

- Постод жижүүрлэн ажиллах албан хаагчдын хуваарийг гарган батлуулах.
- Ажилласан эмч нарын гарааг тооцож холбогдох албан тушаалтад хүргүүлэх.
- Халдвар хамгааллын хувцас ариутгалын бодисыг өдөр бүр олгох.
- Орох гарах иргэдээс авах асуумжийн хуудас нийт 2500, гэрийн тусгаарлалтын баталгааны хуудас 2500, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд өгөх зөвлөмж 2500

ширхэгийг тус тус олшруулсан, харилцаа холбооны хэвийн байдлыг хангах зэрэг болно.

Коронавируст халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан тусгаарлан ажиглах 6 байрны шаардлагатай бэлэн байдлыг байнга ханган ажиллаж байна.

- Тусгаарлах байранд орох, гарах иргэдийг тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.
- Тээврийн хэрэгсэл болон тусгаарлах байрны коридор, өрөө бүрийг тухай бүр ӨЭМТөвөөр ариутгал хийлгэж нь тогмол ариутган халдваргүйжүүлж Аймгийн МХГазрын холбогдох мэргэжилтэнгээр хянуулж ажиллаж байна
- Аюултай хог хаягдлыг Сүхбаатар Хот тохижилт ОНӨААТҮГазартай холбогдон тогтмол ачуулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.
- Тусгаарлан ажиглах байранд орсон 170 иргэний судалгааг жагсаалтаар гаргаж, гэрийн ажиглалтад шилжиж байгаа 90 иргэний мэдээлэл, хаяг, утасны дугаарыг нягтлан шалгаж холбогдох мэргэжилтэд хүргүүлсэн.
- Вакцинжуулалтын мэдээг өдөр бүр гаргаж тайлагнаж байна , 05/02-05/21 хүртлэх хугацаанд Баруун-Урт сумын хэмжээнд 1-р тунгийн дархлаажуулалт 95 хувьтай байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ГЭР БҮЛ ХҮҮХДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Энэ жил 6-н настай 634 хүүхэд шинээр сургууль орох бүртгэл хийгдсэн.
Сумын хамтарсан багийн хурлыг 2 удаа хуралдуулж 3 кейс хаалаа.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ